

Чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөл

Дүрвэгсдийн процедурын тухай мэдээлэл

Чи яагаад энэ товхимолыг хүлээж авав?

Чи Нидерландын Вант улсад дүрвэгсдийн орогнол асуухыг хүсэж байна. Дүрвэгсэд гэдэг нь: эх орондоо аюул заналд учирсан хүмүүс өөрийн эх орноосоо хамгаалалт авч чадахгүйн улмаас өөр улсаас хамгаалалт гуйхыг хэлнэ.

Хэрвээ чи дүрвэгсдийн орогнол асууж өргөдөл өгвөл, Нидерландын Вант улсын засгийн газраас албан ёсоор оршин суух зөвшөөрөл асууж байна гэсэн үг юм. Нидерландын Вант улсад амьдрахад чамд зөвшөөрлийн бичиг баримт хэрэгтэй. Чамайг дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлөө өгсний дараа дүрвэгсдийн процедур эхэлнэ: энэ нь Нидерландын Вант улсын засгийн газар чамд оршин суух зөвшөөрлийн бичиг өгөх эсэхийг шийддэг хууль эрх зүйн үйл ажиллагаа юм.

Энэ товхимолоос дүрвэгсдийн процедур хэрхэн явагддаг тухай уншиж болно. Мөн чиний гүйцэтгэх ёстой (чиний үүргүүд) ба чи Нидерландын Вант улсын засгийн газраас юуг хүсэмжилж болох (чиний эрхүүдийн) тухай уншаарай.

Хэн Нидерландын Вант улсаас хамгаалалт (орогнол) авч чадах вэ?

Дүрвэгсдийн оршин суух зөвшөөрөл

Нидерландын Вант улсын Гадаад иргэдийн тухай хуульд ямар болзлууд бүрдэж байж дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авч чадах тухай заасан байдаг. Дараах тодорхойлолтуудын аль нэг нь чамд таарч байвал чи оршин суух зөвшөөрлийг авч чадна:

- Чи арьсны өнгө, яс үндэс, шашин шүтлэг, гарал угсаа, улс төрийн үзэл бодол эсвэл ямар нэгэн нийгмийн бүлэглэлд хамаарагддагаас шалтгаалж эх орондоо мөрдлөг хавчлагын аюулд өртөхөөс айх үндэслэлтэй шалтгаантай бол
- Чи эх орондоо цаазаар авах ял ба аллагад өртөгдөх, тамлагдаж зовох эсвэл хүнлэг бус эсвэл доромжлогдон гутаагдах аюулд тулгарахаас айж буй үндэслэлтэй шалтгаантай бол
- Чи эх орондоо зэвсэгт мөргөлдөөний хүчирхийллийн улмаас санаандгүй хохирогч болох аюулд тулгарсан ба үндэслэлтэй шалтгаантай бол
- Чиний аав, ээж чинь саяхан Нидерландын Вант улсын дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авсан бол.

Чамайг дээрх дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийн шаардлагуудыг хангаж буй эсэхийг Immigratie- en Naturalisatiedienst (IND) – Дүрвэгсдийн – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага шийдвэрлэдэг.

Чи ямар байгуулгуудад хандах вэ?



Нидерландын Вант улсын хуулиар насанд хүрээгүй дүрвэгч, эцэг эх, өөр асран хамгаалах хүнгүйгээр ганцаараа энэ улсад ирсэн бол (voogdij) – чамд асран халамжлагч олж өгөх ёстой байдаг. **Stichting Nidos** – Нидос байгууллага нь ганцаараа ирсэн насанд хүрээгүй дүрвэгсдийг асран халамжлахыг хариуцаж ажилладаг. Тэд чамд албан ёсоор асран халамжлагч асууж өгдөг. Нидос нэг ажилтнаа чиний халамжлагчаар томилдог. Тэр ажилтан нь чамайг Нидерландын Вант улсад дааж авдаг. Чиний амьдралдаа гаргах чухал шийдвэрүүдэд туслах, чамайг тавтай байранд амьдрахад чинь мөн сургуулийн асуудлыг чинь зохицуулж өгдөг. Мөн асран халамжлагч чиний дүрвэгсдийн процедурт тусалдаг. Гэвч тэд IND – гийн гаргах шийдвэрт бол нөлөө үзүүлж чадахгүй. Асран халамжлагчийн тухай илүү мэдээллийг Нидосоос авна.



COA Centraal Orgaan opvang asielzoekers

Centraal Orgaan opvang asielzoekers (COA) – Дүрвэгсдийг Хүлээн Авах Төв Байгууллага (COA) нь Нидерландын Вант улс дахь дүрвэгсдийг хүлээн авах ба үүнтэй холбоотой асуудлуудыг хариуцдаг. Чи арай арван тав хүрээгүй бол дүрвэгсдийн процедурын үеэр (pleeggezin) – асран халамжлах айлд амьдарна. Хэрвээ чи арван таваас арван найм хүрсэн бол COA - ын дүрвэгч хүүхдүүдэд зориулсан тусгай байранд аваачна. COA чамайг хоол, байраар хангах ба эрүүл мэндийн зардлын даатгалтай болоход тусалдаг. Чи эмчтэй холбогдож тусламж авахаар бол COA-д хандаж болно. COA бол биеэ даасан байгууллага ба чиний дүрвэгчийн асуудлыг шийдэхгүй.



GezondheidsZorg Asielzoekers (GZA) – Дүрвэгсдийн Эрүүл Мэндийн (GZA) байгууллагад чи өвдсөн үедээ болон эрүүл мэндтэйгээ холбогдолтой асуултынхаа талаар хандаж болно. COA-гийн байр болгоны ойролцоо GZA-ийн төв байрладаг. GZA нь чамд эмчийн туслахтай, сувилагч нартай, GGZ- ийн эмчилгээний туслахуудтай болон өрхийн эмчтэйгээ цаг авч уулзахыг чамд зохицуулж өгдөг. Чи өдөр шөнийн аль ч цагт эрүүл мэндийн холбоо барих төвд “Дадлагын дугаар”: 088 112 21 12-луу залгаж асуултуудаа тавьж болно. Энэ дугаарлуу Чи Даваа гаригаас Баасан гариг хүртэл өвчнөөс бусад өөр асуултуудыни талаар залгаж ярьж болно. Жишээ нь Чи нарийн мэргэжлийн эмчид хандахад шаардлагатай бичиг, захиа авахыг хүсч байгаа бол бас залгаж болно.



VluchtelingenWerk Nederland – Нидерландын Дүрвэгсдийн Ажил бол биеэ даасан хүний эрхийг хамгаалах байгууллага бөгөөд дүрвэгсдийн эрх ашгийг хамгаалахын тулд байгуулагдсан юм. VluchtelingenWerk Дүрвэгсдийн Ажил танд болон дүрвэгсдийн процедурын тухай тайлбар ба мэдээлэл өгдөг. Таныг процедураа туулахад, хувийн мэдээллийг тань лавлаж өгөх ба өөр байгуулгуудтай үүссэн асуудлуудыг тань зохицуулж өгөхөд VluchtelingenWerk тусалдаг. Тэд энэ үйл ажиллагаандаа таны өмгөөлөгчтэй хамтран ажилладаг. VluchtelingenWerk таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөл шийдвэр гаргахгүй.

Raad voor Rechtsbijstand legal aid

Raad voor Rechtsbijstand – Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар чамайг өмгөөлөгчийн тусламж аваад зардлыг нь төлж чадахгүй тохиолдолд тусалдаг. Өмгөөлөгчийн чамд үзүүлсэн үйлчилгээний хөлсийг Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар өмгөөлөгчид төлдөг. Өмгөөлөгч бол Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газрын ажилтан биш юм. Өмгөөлөгч бол чиний дүрвэгсдийн процедурт туслалцаа үзүүлэх биеэ даасан хууль эрх зүйн тусламж үзүүлэгч юм.



Immigratie- en Naturalisatiedienst
Ministerie van Veiligheid en Justitie

Immigratie- en Naturalisatiedienst (IND) – Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага нь Нидерландын Вант улсын Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яамны харьяа байгууллага юм. IND-гийн ажилчид чамайг хэн болох, чиний иргэншил харьяалал, ирэхдээ туулсан зам, эх орноосоо дүрвэн гарсан шалтгааны тухай чамтай ярилцдаг. Тэгээд тэд чиний хувийн түүхийг болон эх орны чинь нөхцөл байдлыг судалдаг. Дараа нь тэд чамайг Нидерландын Вант улсад (түр хугацаанд) үлдэж болох эсвэл эх орондоо буцах ёстой эсэхийг шийдвэрлэдэг.



Beveiliging – Хамгаалалт

IND ба COA-гийн хүлээн авах төвийн барилгуудад **хамгаалагч** нар байдаг. Чи тэднийг дүрэмт хувцсаар нь таньж болно. Тэд чиний аюулгүй байдлыг хангадаг. Чи тэднээс IND ба COA-гийн барилгуудад болон талбайд ямар зүйлс зөвшөөрөгдсөн болон хориотой байдгийг асууж болно. Эдгээр хамгаалагчид чиний дүрвэгчийн асуудлыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлэхгүй.



Dienst Terugkeer en Vertrek
Ministerie van Veiligheid en Justitie

Dienst Terugkeer en Vertrek (DT&V) – Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) нь Нидерландын Вант улсын Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яамны харъяа байгууллага юм. Хэрвээ чи татгалзсан хариу авсан бол, чамайг эх орондоо буцах ажлаа зохион байгуулахад DT&V байгууллагын ажилтан тусалдаг.



Internationale Organisatie voor Migratie (IOM) – Олон Улсын Дүрвэгсдийн Төлөөх Байгууллага - IOM чамайг өөрөө сайн дураараа Нидерландын Вант улсыг орхин явах үед тусалж чадна. IOM чамайг буцахад болон дахин эх орондоо эргэн зохицоход тань хэрэгтэй бодит мэдээллийг өгч Нидерландын Вант улсаас явах бэлтгэлээ хангахад чинь тусалдаг. Чи мөн VluchtelingenWerk – (ДүрвэгчдийнАжил) байгууллага эсвэл өмгөөлөгчөөсөө тусламж гуйж болно.

Чамаас юу хүлээж байна вэ?

Дүрвэгсдийн процедурын үеэр чи мэдүүлэг өгөхдөө дүрвэх болсон шалтгаанаа сайн тодорхойлон бататгах нь их чухал юм. Мөн чамайг бүхий л өөртөө байгаа эсвэл олж авч бүрдүүлж чадах (жишээ нь бичиг баримтууд эсвэл чиний мэдүүлгийг батлах захидлууд, гэх мэт) нотлох баримтуудыг IND-д харуулахыг хүсдэг.

Одоо чамд ямар нэгэн хэлэх зүйл байвал түүнийгээ IND-д аль болох хурдан мэдэгдэх нь чухал юм. IND – түүнийг чинь мэдсэнээрээ чиний дүрвэгчийн процедур чинь үргэлжилж чамд аль болох сайн туслахыг хичээх болно.

Дүрвэгсдийн процедур өдөр өдрөөр

IND-тэй тохирсон цагтаа чи IND-гийн байранд очно. Эндээс чиний дүрвэгсдийн процедур эхэлж байна.

Чиний дүрвэгсдийн процедур өдрөөс өдөрт хэрхэн явагддаг талаар үргэлжлүүлэн уншиж болно.

1 дэх өдөр: анхны ярилцлага

Чи IND-гийн ажилтанд өөрийгөө хэн болох, иргэншил харьяалал, ирэхдээ туулсан замынхаа талаар албан ёсны ярилцлага өгнө. Энэ ярилцлаганд IND-гийн ажилтан чиний эцэг эх эсвэл Нидерландын Вант улсад ирэхээс чинь өмнө чамайг асарч байсан хүмүүсийн тухай асууна. Энэ ярилцлагыг нэгдүгээр ярилцлага гэж нэрлэдэг. Хэрвээ чи хүсвэл VluchtelingenWerk-ДүрвэгсдийнАжил байгууллага эсвэл асран халамжлагчаа анхны ярилцлагандаа хамт байлгаж болно.

Энэ ярилцлаганд чиний дүрвэх болсон шалтгааны тухай асуултууд асуухгүй. Тэр талаар дараа нь IND-гийн ажилтантай хийх ярилцлагын үеэр авч хэлэлцдэг(3 дахь өдрийг харна уу). IND-гийн ажилтан чамайг хэн болохыг, хаанаас ирсэн, Нидерландын Вант улс уруу яаж ирсэн тухай тодорхой мэдэхийн тулд маш их нарийвчилж асуултууд асуудаг. Энэ асуултуудаараа тэд чамайг үнэн ярьж буй эсэхийг шалгадаг. Чи анхны бүртгэлийн ярилцлаганд орсон уу? IND-гийн ажилтан чиний мэдүүлсэн өгөгдлийг шалгаж нэмэлт асуултууд чамаас асууна. Чи анхны ярилцлагандаа аль болох сайн бэлдээрэй. Чамд өөрийгөө хэн болох, хаанаас ирсэн тухайгаа ойлгомжтой, бүрэн бүтэн тайлбарлаж ярих ганцхан боломж олдож байна. Хуурамч (аялалын) бичиг баримтынхаа өгөгдлийг биш харин үргэлж өөрийнхөө жинхэнэ төрсөн он сар өдөр, нэрээ өгөөрэй. Хэрвээ чи өөр хуурамч нэр хэрэглэж байсан бол тэрийгээ бас хэлээрэй. Чиний бичиг баримтууд болон ярьсан түүх намтрын чинь жинхэнэ үнэн эсэх нь шалгагддаг. Хэрвээ IND чиний түүхийг худлаа юмуу бичиг баримтуудыг чинь хуурамч гэж тодорхойлбол чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд сөргөөр нөлөө үзүүлэх боломжтой.

IND-тэй ярилцах ярилцлагад хэлмэрч байх болно. IND-гийн ажилтан Нидерланд хэлээр асуултууд асууна. Хэлмэрч тэдгээр асуултуудыг чиний ойлгодог хэл рүү хөрвүүлнэ. Хэлмэрч мөн чиний хариулсан хариултуудыг Нидерланд хэл рүү хөрвүүлнэ. Хэлмэрч бол биеэ дааж ажилладаг ажилтан бөгөөд чиний дүрвэгчийн асуудлыг шийдэхэд нөлөө үзүүлэхгүй. Хэрвээ хэлмэрч та хоёр бие биенээ сайн ойлголцохгүй байгаа бол чи үтэр даруй мэдэгдээрэй. IND чамд өөр хэлмэрч олж өгнө. Чамд асуултаа сайн ойлгоогүйгээс болоод буруу ойлголт үүсэхгүй байх нь чухал юм.

Чи (өмгөөлөгчөөрөө дамжуулан) анхны ярилцлагын тайланг хүлээн авна.

2 дахь өдөр: гүнзгийрүүлсэн ярилцлагадаа бэлдэх

Анхны ярилцлагын тайлангийн тухай чи өмгөөлөгчтэйгөө хэлэлцэнэ. IND-гийн кантоорт өмгөөлөгчтэй ярилцахад зориулагдсан тусгай өрөө байх болно. Энэ ярилцлагын үеэр өмгөөлөгч болон чамд хэлмэрчилж туслах хэлмэрч байх болно. Хэрвээ тайланд дутуу бичигдсэн ба алдаатай зүйлс байвал өмгөөлөгч бичгээр IND-д мэдэгддэг. Чиний өмгөөлөгч чамайг IND –тэй хийх хоёр дахь ярилцлагад бэлдэнэ.

3 дахь өдөр: гүнзгийрүүлсэн ярилцлага

IND-тэй хийх хоёр дахь ярилцлагыг гүнзгийрүүлсэн ярилцлага гэж нэрлэдэг. Энэ ярилцлаганд чи дүрвэх болсон шалтгаанаа ярина.

Энэ ярилцлага нь мөн IND-гийн кантоорт явагддаг. Чамд яагаад хамгаалалт хэрэгтэй байгаа бүх учраа ярих нь их чухал юм. Чамд юу тохиолдсон болон ямар шалтгаанаар чи эх орноосоо хамгаалалт авч чадахгүй байгаагаа чи шударгаар, бүрэн гүйцэд, ойлгомжтой яриарай. Хэрвээ чи ямар нэгэн болсон үйл явдлыг сайн санахгүй байгаа бол IND-гийн ажилтанд тайлбарлаж хэлээрэй. IND-гийн ажилтан чиний эх орны нөхцөл байдлын талаар ерөнхий ойлголттой байгаа. Гэвч чи өөрийнхөө хувийн нөхцөл байдлын талаар ярих нь чухал

юм: Ер нь яагаад чамд хувь хүний хувьд хамгаалалт хэрэгтэй байгаа юм бэ. Чи аль болох түүхтэйгээ хамааралтай мэдээллийг нарийвчилж ярих хэрэгтэй; заримдаа жижигхэн зүйл ч хэрэгтэй мэдээлэлд орж болно. IND-гийн ажилтан чамаас энэ талаар асуултауд асуух болно.

Хэрвээ чамд чиний орогнол асуух шалтгаантай холбоотой шарх сорви, бие махбодийн болон сэтгэл санааны зовуур байгаа бол үүнийгээ IND-гийн ажилтанд хэлж байх нь чухал юм. Хэрвээ IND чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг шийдвэрлэхэд шаардлагатай гэж үзвэл, чамд (эрүүл мэндийн) үзлэг хийх санал болгож болно. Чи бас өөрийн санаачилгаар, өөрийн зардлаар ийм үзлэгийг хийлгэх боломжтой юм. Өмгөөлөгч чинь энэ тал дээр чамд тусалж чадна.

Чиний эх оронд эсвэл урьд өмнө нь амьдарч байсан улс оронд чамайг хэн харж хамгаалж байсан буюу харж хамгаалж чадахгүй байсан талаар ярих нь чухал. IND-гийн ажилтанд мөн энэ тухай бодлоо хуваалцах хэрэгтэй. Энэ ярилцлагад ч хэлмэрч байдаг. Ихэнхдээ чиний өмгөөлөгч эсвэл асран халамжлагч хамт байлцдаг. Хэрвээ чи хүсвэл өөр төлөөлөгчийг ч авчирч болно. VluchtelingenWerk-(ДүрвэгчдийнАжил) байгууллагыг ярилцлагадаа байлгахыг ч хүсэж болно. Чи (өмгөөлөгчөөрөө дамжуулан) энэ ярилцлагын тайланг хүлээж авна.

4 дэх өдөр: гүнзгийрүүлсэн ярилцлагын талаар хэлэлцэх

Чиний өмгөөлөгч чамтай гүнзгийрүүлсэн ярилцлагын тайлангийн тухай хэлэлцэнэ. Энэ ярилцлагад ч хэлмэрч өмгөөлөгч болон чиний хэлсэн болгоныг хөрвүүлж тусална. Хэрвээ тайланд дутуу бичигдсэн болон алдаатай зүйлсүүд байвал өмгөөлөгч бичгээр IND-д мэдэгддэг.

5 дахь өдөр: урьдчилсан шийдвэр

Чамайг IND дүрвэгсдийн оршин суух зөвшөөрөл авах болзлыг хангаж буй эсэхийг дүгнэнэ. Энэ дүгнэлтээс гарах шийдвэр нь чиний дүрвэгсдийн процедур цаашдаа яаж үргэлжлэхийг тодорхойлдог. Энд гурван боломж бий:

1. Чи дүрвэгсдийн оршин суух зөвшөөрөл авах нөхцөл байдлыг хангасан тохиолдолд. Чамд (өмгөөлөгчөөр чинь дамжуулж) IND захидал (=beschikking) (шийдвэр) өгнө. Энэ захидалд чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийн хариуд зөвшөөрсөн хариу өгсөн тухай бичигдсэн байна. Энэ нь чи (түр хугацаанд) Нидерландын Вант улсад үлдэж болно гэсэн үг юм. Өмгөөлөгч чамд энэ нь ямар үр дагавар авчрах тухай тайлбарлаж өгнө.
2. IND-д судалгаа явуулахад илүү хугацаа хэрэгтэй байгаа тул найман хоногийн дотор чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг шийдвэрлэж чадахгүй гэнэ. IND үргэлжлүүлэн чиний дүрвэгсдийн өргөдлийг Дүрвэгсдийн Уртасгасан Процедурээр шийдвэрлэнэ. Чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийн хариу дараа нь гарна. Чи Дүрвэгсдийн Уртасгасан Процедурын талаар тусгай товхимол хүлээн авна.

3. IND чамайг дүрвэгчийн оршин суух зөвшөөрлийг авах болзлыг хангахгүй байна гэсэн шийдвэр гаргах. IND (өмгөөлөгчөөр дамжуулан) чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд татгалзах төлөвлөгөөтэй байна гэж бичсэн захиа өгнө. Энэ нь захидлыг урьдчилсан шийдвэр гэж нэрлэдэг. Энэ захидалд татгалзсан хариу өгөх болсон шалтгаануудыг дурьдаж чамд мөн энэ нь ямар үр дагавар авчрахыг заасан байна. Өмгөөлөгч чамтай уг захидлын талаар хэлэлцэнэ.

6 дахь өдөр: үзэл бодол

Хэрвээ IND чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд татгалзах төлөвлөгөөтэй байгаа бол, чи өмгөөлөгчтөйгөө урьдчилсан шийдвэрийн талаар ярилц. Чиний өмгөөлөгч чамтай урьд нь энэ талаар ярилцаж тохирсон байх ёстой. Үргэлжлүүлэн чиний өмгөөлөгч IND-д бичгээр үзэл бодлоо илэрхийлнэ. Энэ захидалдаа IND-гийн гаргасан урьдчилсан шийдвэрийг албан ёсоор эсэргүүцэж мөн чи ямар шалтгаанаар эсэргүүцэж байгаагаа дурдсан байна.

7 ба 8 дахь өдөр: шийдвэр

IND чиний илгээсэн үзэл бодлыг уншсаны дараа урьдчилан гаргасан шийдвэрээ өөрчлөх эсэхийг шийддэг. Эндээс гарсан шийдвэр дахиад чиний дүрвэгсдийн процедур хэрхэн явагдахыг тодорхойлно. IND гаргасан шийдвэрээ захиагаар чамд (өмгөөлөгчөөр тань дамжуулан) мэдэгдэнэ. Чиний өмгөөлөгч чамд энэ шийдвэр ямар үр дагавартай болохыг тайлбарлаж өгнө. Энд дөрвөн боломж бий:

1. IND чиний илгээсэн үзэл бодлыг уншаад дараа нь чамайг дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах нөхцөл байдлыг хангаж байна гэж үзэх. IND захиа буюу шийдвэр (=beschikking) чамд (өмгөөлөгчөөр дамжуулан) өгнө. Энэ захидалд чиний дүрвэгсдийн өргөдлийн хариуг зөвшөөрсөн гэж бичсэн байна. Чи (түр хугацаанд) Нидерландын Вант улсад оршин сууж болно. Чиний өмгөөлөгч чамд энэ нь ямар өөр үр дагавар авчирч байгааг тайлбарлаж өгнө.
2. IND-д судалгаа явуулахад илүү хугацаа хэрэгтэй байгаа тул найман хоногт чиний орогнол хүссэн өргөдлийг шийдвэрлэж чадахгүй. IND чиний орогнол хүссэн өргөдлийг цаашид Дүрвэгсдийн Уртасгасан Процедурээр шийдвэрлэнэ. Чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийн хариу дараа нь гарна. Чи мөн Дүрвэгсдийн Уртасгасан Процедурын талаар товхимол авна.
3. IND гаргасан шийдвэрээ хэвээр байлгаж чамайг дүрвэгчийн орогнол хүссэн оршин суух зөвшөөрөл авах болзлыг хангахгүй байна хэмээн шийдвэрлэх. Чамд (өмгөөлөгчөөр дамжуулан) IND чиний дүрвэгчийн орогнол хүссэн өргөдлийн хариуд татгалзсан гэж бичсэн (шийдвэр) захиа өгнө. Энэ шийдвэрийн хажуугаар тусад нь хариунаас гарах үр дагаварыг зааж, энэ шийдвэрийн эсрэг авч болох арга хэмжээ мөн буцах боломжуудыг тайлбарласан мэдээлэл өгнө. Энэ шийдвэрт мөн татгалзсан хариуны шалтгааныг дурдаж чамд ямар үр дагавар авчрахыг бичсэн байна. Таны өмгөөлөгч шийдвэрийн тухай чамтай хэлэлцэнэ.
4. IND таны мэдээллийг DT&V – д шилжүүлнэ. Тэд чамтай буцах ярилцага хийж эх орон болон урьд нь амьдарч байсан

улсад чинь чамайг хэн асран халамжлах тухай судалгаа хийдэг. Хэрвээ чи энэ ярилцлагуудад болон судалгаанд хамтран ажиллаад судалгааны үр дүнгээс чамайг буцах ямар ч боломжгүй чи өөрөө үүнд юу ч хийж чадахгүй гэдэг нь тодорхой болбол DT&V эргүүлээд IND – д мэдээнэ. IND чамайг буцаах боломжгүй асран халамжлах хүнгүй насанд хүрээгүй хүүхдийн “buitenschuld” бодлогоор – (буцаах боломжгүйн бодлого) үлдэх зөвшөөрлийн бичиг хүсэх өргөдөл өгөх үү хэмээн асуудаг.

Гаргасан өргөдлөө буцаан татан авах

Чи орогнол хүссэн өргөдлөө хүссэн үедээ буцааж авч болно. Энэ тохиолдолд чи өмгөөлөгчтэйгөө болон асран халамжлагчтайгаа ярилцах нь зөв юм. Хэрвээ хүсвэл шууд IND-д ч хандаж бас болдог. Чи IND-гээс өргөдлөө буцаан авбал чамд энэ улсад өөр шалтгаанаар оршин суух эрх байхгүй л бол Нидерландын Вант улсад үлдэж болохгүй болдог. Чамайг дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлөө буцаах үед Нидерландад өөр ямар ч үндэслэлээр үлдэж болохгүй бол яах вэ? Энэ тохиолдолд чи эх орондоо буцах ёстой. Чамайг буцаах үйл ажиллагаа эхлэх хүртэл чи дүрвэгсдийн байранд байрлана. Дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлөө буцаасныхаа дараа чамд дахин шинээр орогнол хүсэх боломж бий.

Дүрвэгсдийн процедур дууссаны дараа

Хэрвээ IND чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд зөвшөөрсөн хариу өгвөл чи (түр хугацаанд) Нидерландын Вант улсад амьдарч болно. Чи оршин суух зөвшөөрлийн бичиг хүлээн авна. Чи 15 буюу түүнээс дээш настай бол Нидос (Nidos) чамайг жижиг хэмжээний орон сууцны байраар хангана. Хэрвээ чи насанд хүрсэн бол ажил хийж болно, мөн амьдрах байраа өөрөө хайж болно. COA чамд орон сууц олоход тусалж чадна. Чи байраа олтлоо COA-гын байранд амьдарч болно. Чамайг зөвшөөрсөн хариу авсны дараа IND чиний эрх ба үүргүүдийн тухай мэдээлэл өгдөг. Чиний асран халамжлагч болон VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтнууд чамайг төрөл бүрийн байгууллагуудтай холбогдоход, тухайлбал орон сууц олоход, сургууль, ажилд ороход тусална. Мөн VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллага чамд гэр бүлийн гишүүдээ наашаа авчрахад тусалдаг.

Хэрвээ IND чиний орогнол хүссэн өргөдөлд татгалзвал, чи өмгөөлөгчтэйгөө хэлэлцээд Нидерландын Вант улсын шүүгчид энэ шийдвэрийн эсрэг давж заалдаж болно. Энэ нь чи шүүгчид IND- гийн гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаагаа албан ёсоор илэрхийлж байна гэсэн үг юм. Чи мөн шүүгчээс давж заалдах процедурын үеэр Нидерландын Вант улсад үлдээж өгөхийг асууж болно. Үүнд

чиний өмгөөлөгч тусалж чадна. Шүүгч үргэлжлүүлэн IND Нидерландын Вант улсын хуулийн дагуу чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг шийдсэн эсэхийг судална. Ихэнхи тохиолдолд чи шүүгчийн шийдвэрийг гартал нь Нидерландын Вант улсад үлдэж хүлээж болдог.

Хэрвээ IND чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг татгалзсан бөгөөд чи энэ шийдвэрийг шүүгчид давж заалдаагүй бол чамд ихэнхдээ Нидерландын Вант улсыг орхин гарах 28 хоногийн хугацаа өгдөг. Чи эх орондоо буцах хариуцлагыг өөрөө хүлээнэ. Хэрвээ чи заасан хугацаанд өөрөө санаачлагаараа буцахгүй бол чамайг албадан эх оронлуу чинь буцаана. Dienst Terugkeer en Vertrek (DT&V)- Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) нь чамайг буцах үйл ажиллагаагаа зохион байгуулахад чинь тусалдаг. Чамайг буцаах үйл ажиллагаа эхэлтэл чи дүрвэгсдийн байранд байх болно.

Хэрвээ IND чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд татгалзсан бол, чи эх орондоо хэрхэн буцах тухай товхимол гардан авна. Хэрвээ чи эх орондоо санаачлагаараа буцах хүсэлтэй бол, Internationale Organisatie voor Migratie (IOM)- Олон Улсын Дүрвэгсдийн Төлөөх Байгууллагатай холбоо барьж болно. IOM чамайг буцахад тусалж бодитой мэдээлэл өгнө. Ихэнх дүрвэгсдийн төвүүд дээр IOM-той ярилцах цаг авч болох ба янз бүрийн хотуудад IOM-ийн ажилтантай уулзах боломжтой. Чиний дүрвэгсдийн процедур дууссан ч гэсэн чи асран халамжлагч болон VluchtelingenWerk – (ДүрвэгсдийнАжил) байгууллагаас тусламж болон мэдээлэл авч болно.

Буцах боломжгүй нөхцөлд олгох оршин суух зөвшөөрөл

Албан ёсны оршин суух эрхийн бичиг

Насанд хүрээгүй, ганц бие дүрвэгсдэд тусгай журам заасан байдаг. Хэрвээ чи орогнол асууснаасаа хойш гурван жилийн дотор эх орондоо буцаж чадаагүй бөгөөд чи өөрөө үүнд ямар ч арга хэмжээ авч чадахгүй байсан тохиолдолд чи тусгай оршин суух эрхийн зөвшөөрөл авч чадна. Энэ тусгай buitenschuldvergunning (буцах боломжгүй үед олгох зөвшөөрлийн) бичгийг авахын тулд хэд хэдэн болзлууд бүрдсэн байх ёстой:

- Чи дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлдөө татгалзсан хариу авсан
- Анх бүртгүүлж байхдаа 15 нас хүрээгүй, үүнээс бага настай байсан
- Чи 18 – аас доош насных бөгөөд гэрлээгүй
- Чи Нидерландын Вант улсад ганцаараа байдаг, эцэг эх чинь байхгүй буюу чамд гадаадын аль нэгэн улсад асран халамжлагч байхгүй
- Эх оронд чинь эсвэл урьд нь амьдарч байсан улс оронд чинь чамайг асран халамжлах хүмүүс болон байгууллага байхгүй бол

- Урьд нь чи (ганцаараа эсвэл, асран хамгаалагчтайгаа, эсвэл өөр насанд хүрсэн хүнтэй хамтран) чамайг буцаах үйл ажиллагаанд хамтран ажиллаж байсан.
- Чамаас хамааралгүй шалтгаанаар чи эх орондоо эсвэл урьд нь амьдарч байсан улс оронлуу буцаж чадахгүй байна.

Энэ болзлуудыг хангахаас гадна орогнол асууснаас хойш гурван жилийн хугацаа өнгөөрөөгүй байх ёстой.

Мөн Нидерландын Вант улсад дүрвэгсдийн орогнол асуухдаа чи арван таваас дээш настай байсан бол энэ албан ёсны (buitenschuldvergunning) буцах боломжгүй нөхцөлд олгох зөвшөөрлийн бичгийн журамд хамрагдах боломжтой. Энэ тохиолдолд чи IND – д эх орондоо буцах ямар ч боломжгүй гэдгээ хангалттай баримтаар нотлох хэрэгтэй. Үүнд гурван болзол байдаг:

- Чамайг буцаж очихыг эх орны чинь юм уу эсвэл амьдарч байсан улс орны засаг захиргаа зөвшөөрөхгүй байх
- Засаг захиргаанаасаа авах буцах бичиг баримтыг бүрдүүлэхдээ чи өөрөө санаачлага гаргаснаа нотлох ёстой
- Чи эрүүл мэндийн асуудлаас болоод буцаж чадахгүй байх

IND чамайг асран халамжлах хүнгүй, насанд хүрээгүй хүүхдийн буцах боломжгүйн buitenschuld- журмаар үлдэх зөвшөөрлийн бичиг авах болзлуудыг бүрдүүлж буй эсэхийг шийддэг.

Хүний наймааны хохирогчдын оршин суух зөвшөөрлийн бичиг

Хэрвээ чи хүний наймааны хохирогч бол тодорхой хугацаанд оршин суух албан ёсны зөвшөөрлийн бичиг авч болдог. Энэ бол түр зуурын зөвшөөрлийн бичиг юм. Чи дараах болзлуудыг хангасан байх ёстой:

- Чи хүний наймааны хохирогч юм.
- Чи мэдүүлэг өгсөн эсвэл өөр замаар гэмт хэргийн сэжигтнийг эрэн суралжлах- эсвэл мөрдөн байцаах, мөрдлөгийн үйл ажиллагаанд тусалсан бол.
- Гэмт хэргийн сэжигтнийг эрэн суралжлах- эсвэл мөрдөн байцаах, мөрдлөгийн үйл ажиллагаанд хамтран ажилласан тохиолдолд

Immigratie- en Naturalisatiedienst (IND) – Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага IND чамайг хүний наймааны хохирогчийн зөвшөөрлийн бичиг авах болзлуудыг хангасан эсэхийг шийдвэрлэдэг.

Хувь хүний мэдээллийн боловсруулалт

Хувь хүний мэдээлэл бол чиний талаарх бүх төрлийн мэдээлэл юм. Энэ товхимолын доор бидэнтэй хамтран ажиллаж буй байгууллагуудын нэрсүүд байгаа. Эдгээр байгууллагууд чиний өргөдөл, мэдэгдэл эсвэл хүсэлтийг боловсруулах явцдаа чиний хувийн мэдээллийг ашигладаг. Чамаас тэд чиний мэдээллийг асуугаад хэрвээ шаардлагатай бол бусад байгууллагууд, хүмүүсээс чиний тухай мэдээллийн талаар лавладаг. Эдгээр байгууллагууд чиний өгөгдлийг ашиглаад, хадгалж, хуулийн дагуу шаардлагатай бол бусад байгууллагуудад мэдээллийг дамжуулдаг. Хувь хүний нууцлалын тухай хууль тогтоомжинд чиний өгөгдлийг боловсруулдаг байгууллагуудын дагах ёстой үүргүүдийг заасан байдаг. Жишээлбэл, тэд чиний өгөгдлийг анхааралтай, аюулгүйгээр боловсруулах ёстой. Хувь хүний нууцлалын тухай хуулинд мөн чиний эрхийн талаар заасан байдаг, тухайлбал:

- Байгууллагуудаас өөрийн мэдээллийн талаар асууж мэдэх;
- Байгууллагууд чиний өгөгдлөөр юу хийдэг, яагаад чиний өгөгдлийг хуримтлуулж байгаа гэдгийг мэдэх;
- Цаашлаад ямар байгууллагуудад чиний мэдээллийг дамжуулж өгч байгааг мэдэх эрхтэй.

Чи өөрийн хувийн мэдээллийн боловсруулалт болон өөрийн эрхийн талаар илүү ихийг мэдэхийг хүсч байна уу? Тэгвэл тухайн байгууллагуудын вэбсайтуудыг судлана уу. Энэ товхимлын доод хэсэгт чи тэдгээр байгууллагуудын вэб хаягуудыг олж болно.

Түгээмэл асуултууд

Миний анхны IND-д өгөх ярилцлага хэзээ болох вэ?

Чамд ирснээ бүртгүүлсний дараа дүрвэгсдийн процедуртаа бэлдэх хамгийн багадаа л гурван долоо хоног байгаа. Бодит байдал дээр IND-гийн анхны ярилцлага хамгийн багадаа гурван долоо хоног болж байж болдог. COA-гийн дүрвэгсдийг хүлээн авах төвд эсвэл асран халамжлагч айлд IND-д өгөх анхны ярилцлагын урилгын захиа чамд ирнэ.

Би IND-гийн шийдвэр гартал хир удаан хүлээх ёстой вэ?

Дүрвэгсдийн процедур хамгийн багадаа ажлын найман өдөр үргэлжилдэг. IND-гийн кантоорууд нь ихэнхдээ хагас-бүтэн сайн өдрүүдээр хаалттай байдаг. Эдгээр нь ажлын өдрүүд биш юм. Заримдаа IND ажлын найман өдөрт амжуулж шийдэж чаддаггүй. Жишээ нь чамайг дүрвэгсдийн процедурын үеэр өвдөх тохиолдолд. Энэ үед IND чиний орогнол хүссэн өргөдөлд шийдвэр гаргахын тулд ажлын зургаан өдөр нэмж авдаг.

Мөн IND чиний дүрвэгчийн орогнол хүссэн өргөдлийг үргэлжлүүлж Дүрвэгсдийн Уртасгасан Процедурээр шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд IND чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг хамгийн удаандаа зургаан сарын дотор шийдэх ёстой. Энэ хугацааг чиний дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд гарын үсэг зурснаас эхэлж тоолно. Чи тэгээд Дүрвэгсдийн Уртасгасан Процедурын тухай шинээр товхимол хүлээж авна. Хэрвээ IND зургаан сарын дотор шийдэж чадахгүй бол, IND-гээс чамд мэдээ ирнэ. Хэрвээ чи IND-д орогнол хүссэн өргөдлөө өгснөөс хойш зургаан сараас илүү хугацаа өнгөрч, чамд IND шийдвэрээ явуулаагүй ба IND-гээс мэдээ ирээгүй бол яах вэ? Чи тэгвэл IND-ээс бичгээр хоёр долоо хоногийн дотор чиний дүрвэгчийн орогнол хүссэн асуудлыг шийдэхийг шаардаж болно. Өмгөөлөгч чинь үүнд тусалж чадна. Чиний өмгөөлөгч шүүгчид хандаснаар IND-ээс шийдвэр гаргаагүй удсан хоног бүрээр торгуулийн мөнгө төлүүлэх боломжтой.

Би дүрвэх болсон түүхээ эмэгтэй хүнд ярих хүсэлтэй байна. Энэ болох уу?

Нидерландын Вант улсад чи өдөр тутмын амьдралд эмэгтэй, эрэгтэй хүмүүстэй аль алинтай нь харьцахаас зайлсхийх аргагүй юм. Нидерландын Вант улсын нийгмийн тогтолцоонд эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш эрхтэй.

Чамайг энэ эрхийг ч бас хүндлээсэй гэж бид хүсэж байна.

Хэрвээ чи үнэхээр эмэгтэй IND-гийн ажилтантай илүүтэйгээр дүрвэх болсон шалтгааныхаа тухай ярилцахыг хүсвэл, үүнийгээ IND-гийн анхны ярилцлаган дээрээ мэдэгдээрэй. IND мөн эмэгтэй хэлмэрчийг гүнзгийрүүлсэн (= хоёр дахь) ярилцлагын үеэр байлгахыг хичээх болно. Чи магадгүй эрэгтэй хүнд дүрвэх болсон түүхээ яримаар байна уу? Үүнийгээ мөн л IND-гийн анхны ярилцлаган дээрээ мэдэгдээрэй. IND мөн л гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр эрэгтэй IND-гийн ажилтан ба хэлмэрч байлгахыг хичээх болно.

Хэрвээ чи өвдсөн бол юу хийх ёстой вэ?

Хэрвээ чи өвдсөн юмуу жирэмсэн бол эрүүл мэндийн үзлэгт орохдоо сувилагчид мэдэгдээрэй (товхимолыг унш: Чиний дүрвэгсдийн процедур эхлэхээс өмнө). Хэрвээ чи өөрийгөө сүрьеэ, хамуу, гепатит Б гэх мэтийн халдварт өвчтэй эсвэл чи өөрийгөө өвдсөн байх гэж таамаглаж байгаа бол үүнийгээ хэлэх нь маш чухал юм. Чиний сувилагчид ярьсан болгон чинь нууцлагддаг. Чиний зөвшөөрөлгүйгээр сувилагч эрүүл мэндийн талаарх мэдээллийг хэнд ч өгөхгүй. Чамайг хүсвэл сувилагч IND-д мэдээлэл өгснөөр IND чиний ярилцлагын үеэр эрүүл мэндийн асуудлыг чинь чинь хүндэтгэн үзэж чадах юм.

Хэрвээ чи дүрвэгсдийн процедурынхаа үеэр өвдвөл асран хамгаалагч, COA, IND юмуу VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтангуудад мэдэгдээрэй. Тэд чамайг зөв тохирсон (эрүүл мэндийн) тусламж авахад тусална. Хэрвээ чи IND юмуу өмгөөлөгчтөйгөө уулзах өдрөө өвдвөл, асран хамгаалагч, COA-гийн ажилтнаас өмгөөлөгчдөө юмуу IND-д чамайг өвчтэй байгааг дамжуулж хэлэхийг хүсээрэй.

Энэ товхимолыг уншсаны дараа чамд асуух зүйл байна уу?

Чамд асуултууд байгаа бол өөрийнхөө асран халамжлагч, өмгөөлөгч юмуу COA, IND юмуу VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтнуудын нэгнээс нь асуугаарай.

Чи гомдолтой байна уу?

Бүх дүрвэгсдийн процедуртай холбоотой ажилладаг байгууллууд мэргэжлийн түвшинд, хянамгай ажилладаг. Хэрвээ чи үнэхээр ямар нэгэн байгууллага чамд муугаар хандсан гэж үзэж байгаа бол, гомдол мэдүүлж болно. Чиний өмгөөлөгч юмуу VluchtelingenWerk- (Дүрвэгсдийн ажил) байгууллагын ажилтан чамд туслах болно.

Энэ нийтлэлийг хамтран гаргасан:

Дүрвэгсдийг Хүлээн Авдаг Төв Байгууллага (COA) | www.coa.nl

Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) | www.dienstterugkeerenvertrek.nl

Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага (IND) | www.ind.nl

Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар | www.rvr.org

Нидерландын ДүрвэгсдийнАжил байгууллага | www.vluchtelingenwerk.nl

Даалгавраар бичигдэв.

Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яам, Дүрвэгсдийн асуудал хариуцсан захиргааны www.rijksoverheid.nl

Энэ нийтлэлийн агуулгад зохиогчийн эрхийг түгээх боломжгүй. Хэрвээ орчуулгад утга санааны зөрөө гарвал Нидерланд хэл дээрхи нийтлэлийг дагана.